



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/89

Зуунмод

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 дугаар зүйлийн “а”, “л”, 29.2, 30 дугаар зүйлийн 1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.4, 11.2, 11.3.3, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

1.1. Улаанбаатар хотоос хязгаарлалтын дэглэмд ороод ирж буй иргэдийг гэрийн ажиглалтад байлгаж тусгай GPS программыг сумруу нэвтэрч буй иргэн бүрийн гар утсанд суулган хяналт тавих;

1.2. Нийслэл хотод бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд сумаас орох, гарах хөдөлгөөнийг бүрэн хязгаарлаж зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгаантай иргэн, хүнс барааны татан авалт, өвс тэжээлийн, шатахуун, түлшний тээврийг зохих журмын дагуу аймгийн Шуурхай штабын жижүүрээс чиглэл авч хөдөлгөөн үйлдүүлэх;

1.3. Дамжин өнгөрч буй бусад аймаг орон нутгийн иргэдийг сумын төвд зогсоохгүй худалдаа үйлчилгээний газруудаар үйлчлүүлэхгүй байх арга хэмжээг авч, түүнд тавих хяналтыг нэмэгдүүлэх;

1.4. Хязгаарлалтын дэглэмийг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж байгууллагын албан тушаалтныг тухай бүрт нь холбогдох хууль, дүрэм, журмын дагуу арга хэмжээ тооцож ажиллах;

1.5. Сар шинийн баяр, амралтын өдрүүдэд төрийн байгууллагын албан хаагчдыг хуваарьт оруулан болзошгүй гамшиг осол болон цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төв суурин газрын гудамж талбайгаар хөдөлгөөнт эргүүлийг гаргах мөн байнгын ажиллагаатай замын шалган нэвтрүүлэх хяналтын цэгийг гарган, өдөр тутмын үйл ажиллагаанд Засаг дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга нар өөрийн биеэр хяналт тавьж ажиллахыг тус тус үүрэг болгосугай.

2. Улаанбаатар хотоос хязгаарлалтын дэглэмд орсон иргэдийн судалгаа тоог бодитоор гарган Нийслэлийн Онцгой комисстой харилцан уялдаатай ажиллаж, замын шалган нэвтрүүлэх цэгүүдийн ажиллагааг сайжруулж тавигдах хяналтыг өндөржүүлж ажиллахыг Зуунмод, Лүн, Эрдэнэсант, Баянчандмань, Баян, Эрдэнэ, Батсүмбэр, Сэргэлэн сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. 2021 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрийг дуустал батлагдаагүй замаар зорчиж буй иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих 24 цагийн байнгын хяналтын цэгийг ажиллуулж үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар /Н.Төмөрбаатар/, Цагдаагийн газар /Б.Ганзориг/-т тус тус даалгасугай.

4. 2021 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрийг дуустал 24 цагийн байнгын хяналтын цэгт үүрэг гүйцэтгэх албан хаагчдыг томилгоожуулан, техник хэрэгсэл, автомашины бүрэн бүтэн байдал, бэлтгэл бэлэн байдлыг хангуулж ажиллахыг төрийн байгууллагын дарга удирдлагуудад үүрэг болгосугай.

5. Сумдын Эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийж албан хаагчдыг үүрэгжүүлэхийг Эрүүл мэндийн газар /С.Мөнхтуяа/-т даалгасугай.

6. Баяр амралтын өдрүүдэд үүрэг гүйцэтгэх албан хаагчдын эрүүл ахуй, халдвар хамгааллаас урьдчилан сэргийлэх түр журмыг боловсруулан, мэргэжлийн заавар зөвлөмжийг хүргүүлж, голомттой бүс нутгаас сум орон нутагт ирсэн иргэдийг GPS тусгай программаар бүртгэж байгаад хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /У.Өлзийцэцэг/, Эрүүл мэндийн газар /С.Мөнхтуяа/ нарт тус тус үүрэг болгосугай.

7. Үүрэг гүйцэтгэх албан хаагчдын томилолт, шатахууны зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

8. Шаардагдах зардал 2.149.500 /Хоёр сая нэг зуун дөчин есөн мянга таван зуун/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ю.Бямбацогт/-т зөвшөөрсүгэй.


9. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Сурмаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2021 оны
02 дугаар сарын 08 -ны өдрийн
А/89 дугаар захирамжийн хавсралт



**КОВИД -19 ЦАР ТАХАЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЦЭГТ АЖИЛЛАХ
 АЛБАН ХААГЧДЫН ШАТАХУУН, ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Ажиллах цэг	Ажиллах хүч				Хоног	Ажиллах цэгтээ очих, буцах болон эргүүл хийхэд шаардлагатай шатахуун					Шаардлагатай томилолтын зардал		Бүгд шаардлагатай зардал
		ОБГазар	Цагдаагийн газар	Жолооч	Бүгд		Зуунмодноос / км/	Тав хоногт шаардагдах шатахуун /литрээр/	Нэг хоногт шаардагдах шатахуун /литрээр/	НБҮнэ	Нийт үнэ	Нэг хоногт шаардагдах 1 хүний томилолт 12.000 төгрөг	Нийт үнэ	
1	Ногоон дов	1	1	1	3	5	30	30	150	1,470	220,500	36,000	180,000	400,500
2	Хөшигтийн хөндий	1	1	1	3	5	15	30	150	1,470	220,500	36,000	180,000	400,500
3	Цагдуултын даваа	1	1	1	3	5	18	30	150	1,470	220,500	36,000	180,000	400,500
4	Цонжин болдог орчим	1	1	1	3	5	60	40	200	1,470	294,000	36,000	180,000	474,000
5	Цагаан хөтөл	1	1	1	3	5	60	40	200	1,470	294,000	36,000	180,000	474,000
Нийт		5	5	5	15	25	183	170			1,249,500		900,000	2,149,500

ТООЦОО ХИЙСЭН:

АХЛАХ НЯГТЛАН ХОШУУЧ:

Г.МӨНХСӨЁЛ